

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

XXXVIII (412)

2014

(81-90)

“Билиг сургаал” дахи дүрслэлийн ур маяг

С.Дашдэжид⁷⁹

Эзэн Чингис хаан хөвгүүд, дүү нар, охид гүнж, өрлөг сайдууддаа сурган өгүүлэхдээ өтгөс өвгөдийн үгийг эш болгон, утга уянга төгс, мэргэн сургаалаа уран яруу дүрслэн шүлэглэдэг байжээ. Хожмын сурвалж бичигт тэмдэглэхдээ ч энэ хэлбэрийг алдуулаагүй байна.

Судлаачаас “Монголын нууц товчоо”-г уншихад тэр үеийн ардын зүйр цэцэн үг, сургаал, ерөөл, магтаал, бэлгэтэй үг тэргүүтнээр чимэглэн бичсэн төдийгүй зохиогч өөрийн үзэл бодлыг жинхэнэ уран сайхны аргаар яруу сайхан шүлэглэн бичжээ. Ийм учраас “Нууц товчоо”-ноос тэр үеийн монгол шүлгийн нийтлэг дүр зургийг олж үзэж болно” [Д. Цэрэнсодном, 2008, 110]⁸⁰ гэжээ. Толгой, сүүл холбон эн зэрэгцүүлэх нь монгол шүлгийн өвөрмөц онцлог бөгөөд энэ нь Чингис хааны айлдсан билиг сургаалд тодорхой харагдана. Айзам хэмнэлт гүн утгат дүрслэг хэллэгээр хэлэх гэсэн санаагаа уран яруу илтгэсэн нь билиг сургаалыг сонсоод чихнээ хоногших, цээжлэн тогтоох, утга учрыг нь зөв ухааран ойлгох, бусдыг сургахад үг болон утга үл гажуудах төдийгүй хожмоо зүйр цэцэн үгийн шинжтэй болсон байдаг.

Олон билиг сургаалд дүрслэх яруу хэрэглүүрүүдийг чадамгай ашиглаж, хэлэх гэсэн санаагаа шууд илэрхийлэлгүй харин адилавар ойролцоо шинж бүхий араатан жигүүртний авир төрх, үйл үйлдлээр адилтган зүйрлэж, төлөөлүүлэн дүрсэлж утга санаагаа урнаар илтгэжээ. Жишээлбэл,

[МНТ §164]

sūdtū moqai-a sūdūrte'esū

sūdūrgen-tūr bu oroya

sūdū-'er ama-'ar ūgūleldūjū būsireya

ara'atu moqai-a adarda'asu

adarqan-i inu bu abulcaya

ama-'ar kele-'er olulcaju būsireye [Igor de Rachewiltz, 1972, 77]⁸¹

Чингис хаан Ван хантай Туулын Хар түнд хурж, эцэг хөвгүүн хэмээлцэж, бидний дунд атаат хүмүүний ховын муу үг орвол нүүр учран хэлэлцэж, худал үнэнийг шүүж

⁷⁹ МУИС, Шинжлэх ухааны сургууль, Хүмүүнлэгийн ухааны салбарын Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн багш, докторант

⁸⁰ Д.Цэрэнсодном, *Монголын нууц товчооны утгазүй, уран сайхны шинжилгээ*, Улаанбаатар, 2008, 110

⁸¹ Igor de Rachewiltz, *Index to The Secret History of the Mongols*, by Indiana University, Bloomington 1972, pp.

байхыг сануулжээ. “Шүдэт могой”, “араат могой”-той атаач, хорон сэтгэлт ховч хүнийг адилтган, “могой”-г хүншүүлж, “шүдээр”, “амаар” өөрсдийн биеийг төлөөлүүлэн дүрслээд хажуугийн хүнд хатгагдаж, адарч эвдрүүлэхэд нь бүү автъя, дамын үг дамжиггүй байдгийг ихэд сэрэмжлэн анхаарч “*хажуугийн ховч хүний халтай муу үг, хөндлөнгийн муу хүний хөвсөргөн үг*” нь эцэг хөвгүүн, анд нөхөд, эр эм, улс гэрийг ч хөнөөн салгах аюултайг урнаар илэрхийлжээ.

Чингис хааны сургаалд хүмүүний тэсвэр хатуужил, уян хатан чанарыг араатан амьтны авир төрхтэй холбон өгүүлсэн зүйл олон бий. Энэ нь монголчуудын дүрслэх сэтгэлгээ илүү хөгжсөнтэйхолбоотой. Тухайлбал, Чингис хаан дайжин дутаасан Хасарыг Сүбээдэй баатраар нэхүүлэхэд сургасан сургаалаас тодорхой харж болно. Энэ сургаал Лувсанданзаны “Алтан товч”, “Хаадын үндсэн хураангуй Алтан товч”, “Чингис хааны Алтан товч нэртийн цэди”, Саган сэцний “Эрдэнийн товч”, Инжаннашийн “Хөх судар” зэрэг түүхэн сурвалжаар уламжлан иржээ. Хасарт соён сургасан сургаалын агуулга “Турван зуун тайчуудыг дарсан домог”, “Наймалжин эмгэний сургаал”-тай давхцаж байгаа тул харьцуулан, задлан шинжилгээ, тайлал тайлбар хийхийг зорьсон юм.

Сурвалж тус бүрд байгаа билиг сургаалын хувилбаруудыг зэрэгцүүлэн тавибаас тус бүрийн утга, уран санаа, дүр дүрслэл, хэл найруулгын онцлог нь тодорхой харагдах тул шад шадаар нь харьцуулан үзүүлэв:

[Лу. АТ. Н]⁸² Айлдаа алаг бяруунаас номхон яваад,

[Лу. АТ. ГЗТ]⁸³ Айл зуур явахуйд

Алаг бяруу мэт аашт

[ХС]⁸⁴ Айл зуур явахуйд, алаг бяруу мэт аашит

[Лу. АТ. Н] Алалдах өдөд⁸⁵ хүрвээс

Ал начнаас хатуун хөдлөгтүн.

[Лу. АТ. ГЗТ] Алалцахуй дайсанд

Амь биеэ үл хайрлагч Хүлүг Боорчи минь!

[ХС] Алалдах дайсанд орвоос, амь биеэ үл хайрлагч

⁸²[Лу.АТ. Н]: Lubsangdanjin, *Erten-ь qad-un ьndьsьlegsen түрь yosun-u jokiyal-i tobčilan quriyaysan altan tobči kemekü orusibai*. Orusil bičigsen Ša.Bira, Ulus-un töb nom-un sang-dur qadaγalaydaju bui Lubsangdanjin-u γar bičimel eke-eče gerel jiruy beledkegsen So.Törübatu, Ulus-un keblel-ьн γajar, Ulayanbayatur, 1990, 95b 4-96a 7

Энэ сургаалыг Чингис хаан, Ван хаан хоёр эцэг хөвгүүн хэмээлдэж, амраглан явахуйд Наймалжин эмгэн өгүүлсэн гэх боловч Чингис хааны билигт буй сургаалууд орсон байгаагаас үзвэл гагц Наймалжин эмгэний сургаал биш юм. Энэ тухай өвөрлөгч эрдэмтэн Г.Намжил, Чойжи, Захчидсэцэн нар судалгаандаа тодорхой дурдсан байдаг.

⁸³ [Лу.АТ. ГЗТ]: Лувсанданзаны “Алтан товч”-д буй “Турван зуун тайчуудыг дарсан домог”-ийг ийнхүү товчлон тэмдэглэлээ. Энд Боорчийг магтан сайшаасан хэсэг нь Чингис хааны сургаалтай агуулгаар давхцаж байна. Энэ нь Эзний урьд айлдан сургасан сургаал үгсийг ёсчлон дагаж өөрийн амьдралын мөрдлөг, хэв журам болгосон үлгэр жишээ болно.

⁸⁴ [ХС]: В.Инжаннаши, “Хөх судар”, Тэргүүн дэвтэр, Кирилл үсэгт хөрвүүлсэн Ш.Чоймаа, М.Баярсайхан, Улаанбаатар, 2005, 201-203.

⁸⁵ Өдөд: өдрүүд

[Лу. АТ] **Үтэл⁸⁶ явахуйд**
 [Лу. АТ. Н] Иргэндээ бүхүйд
 [Ху. АТ]⁸⁷ *Утэл явахуйд*
 [АТНЦ]⁸⁸ Үтэл явахуйд

[Лу. АТ] **Итэм⁸⁹ бяруу мэт яв**
 [Лу. АТ. Н] Итэм бяруунаас номхон яваад,
 [Ху. АТ] *Итэм бяруу мэт яв*
 [АТНЦ] Итэм бяруу мэт яв
 [ЭТ]⁹⁰ Инээхүй үйлст итэм бурууд мэт халгин яв
 [Лу. АТ. ГЗТ] Итэм хар бяруу мэт аашт
 [Лу. АТ. ГЗТ] Инээлдэн явахуй цагт

[Лу. АТ] **Идэвхийлэх дуулих⁹¹ үйлст**
 [Лу. АТ. Н] Идэвхийлэх өдөд хүрвээс
 [Ху. АТ] *Идэвхийлэх дуулах үйлд*
 [АТНЦ] Идэвхийлэх үйлсэд
 [Лу. АТ. ГЗТ] Идэвхийхүй дайсанд

[Лу. АТ] **Идлэг⁹² шувуу мэт довтлон яв.**
 [Лу. АТ. Н] Идлэг шувуунаас хатуун хөдлөгтүн.
 [Ху. АТ] *Идлэг шувуун мэт довтлон яв*
 [АТНЦ] Идлэг шувуу мэт довтлон яв
 [ЭТ] Идэвхийлэх үйлст итлэг шувуу мэт дуулин яв
 [Лу. АТ. ГЗТ] Идлэг шувуу мэт туулин довтлон ирэгч
 Хүлүг Боорчи минь!

Эдгээр хэдэн хувилбарыг харьцуулахад зарим үг хэллэгийн зөрүү байхаас биш, утга санааны хувьд онцын зөрүү харагдахгүй байна. Гол утга нь дайн тулаангүй ерийн өдөр, инээлдэн наадан явах цагт бол хүүхэд багачуудын ноолдог номхон алаг бяруу мэт

⁸⁶ Үтэл: энгийн

⁸⁷ [Ху.АТ]: Хаадын үндсэн хураангуй алтан товч, Тэргүүн дэвтэр, Галиглаж үгийн хэлхээ үйлдэн, эх бичгийн судалгаа хийсэн Ш.Чоймаа, Улаанбаатар, 2002,

⁸⁸ [АТНЦ]: Чингис хааны алтан товч нэртний цэди, Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн С.Дашдэжид, Улаанбаатар, 2006, 23-24.

⁸⁹ Итэм: “Манжаар бяруу хэмээсэн үг. Монгол хэлний хөгжлийн Дундад эртний үед монголын зүүн аялгуунд “итэм”, баруун аялгуунд “буруу, буругу”, төв аялгуунд “бируу, биругу” гэх мэтээр хэлэлцдэг байжээ гэж үзэлтэй. Булаг абугай “Хураангуй Алтан товч”-ийг харгуулан тайлбарлахдаа энэ үгийг “ядам хуруу” гэдэг үгтэй холбон “ядам бяруу” буюу жижиг бяруу гэсэн үг, эсвээс Ядам бурхантай холбогдоно гэж үзсэн байна. Түүний ташаа тайлбарлахын үндэс нь манжийн хааны зарлигаар хэвлэсэн монгол, манж, хятад хэлээр барласан “Эрдэнийн товч”-д тийм ташаа бичлэг байдгаас үүдсэн бизээ” гэсэн М.Баярсайхан багшийн тайлбарыг авлаа.

⁹⁰ [ЭТ]: Sagang Secen, “Erdeni-yin tobcī”, (Precious Summary), The Urga text transcribed and edited by, M.Go, I.de.Rachewiltz, J.R.Krueger and B.Ulaan, Faculty of Asian studies, The Australian National University, 1990, 56-57.

⁹¹ Дуулин: Уулгалан дайрч олз авах. Энэ үг нь “довтлон дайрах, (харцага шонхор) халин дайран барих”-ыг заадаг гол утгатай эртний монгол үг.

⁹² Итлэг: Нэг зүйл начин шувуу бөгөөд сургаж сойж, ан авд ашигладаг. Түрэг манжаар адил нэрлэдэг.

ааш зантай байх авч аюумшигт цуст тулаан, дайн дайсны дунд тулалдах нь эсвэл хүчин зүтгэл зарах учиртай их үйл хэргийн төлөө бол амь биеийг өчүүхэн ч үл хайрлан ан гөрөөний олз омогт шунан шунгах идлэг шонхор, начин шувуу мэт байдаг хэмээн зүйрлэжээ. Сонирхолтой нь тэр цагийн монголчуудын гол эрхэлдэг аж ахуй болох ан агнуур, мал ахуйн соёлтой шууд холбоотой хоёр зүйрлэл байгаа юм.

[Лу. АТ. Н] Халуундаа бүхүйд
[Лу. АТ. Н] Хархан бяруунаас номхон явагдах.
[Лу. АТ. Н] Хатгалдах өдөд хүрвээс
[Лу. АТ. Н] Хар начнаас хатууд хөдлөгтүн

[Лу. АТ] **Наадан цэнгэн явахуйд**
[Ху. АТ] *Наадан цэнгэн явахуйд*
[АТНЦ] Наадан цэнгэн явахуйд
[Лу. АТ. ГЗТ] Наадан инээлдэн явахуй цагт

[Лу. АТ] **Нялх унага мэт яв**
[Ху. АТ] *Нялх унага мэт яв*
[АТНЦ] Нялх унага мэт яв
[Лу. АТ. ГЗТ] Нялх унага мэт аашт
[ЭТ] Наадахуй үйлст нялх ботго мэт тамтран яв
[ХС] Инээн наадахуй цагт, идэр зөгий аашит

[Лу. АТ] **Наад цаад лугаа цавчилдахуйд**
[Ху. АТ] *Наад цаад лугаа цавчилдахуйд*
[АТНЦ] Наад цаад лугаа цавчилахуйд
[Лу. АТ. ГЗТ] Наад цаад лугаа хатгалдахуйд

[Лу. АТ] **Начин⁹³ шувуу мэт дуулин довтлон явагтун, та нар.**
[Ху. АТ] *Начин шувуу мэт туулин довтлон явагтун та*
[АТНЦ] Начин шувуу мэт дуулин яв
[ЭТ] Наалдахуй үйлст начин шувуу мэт дуулин яв
[Лу. АТ. ГЗТ] Начин шонхор мэт туулин довтлон орогч
Хүлүг Боорчи минь!
[ХС] Идэвхийлэх дайсанд учирваас, итэлхү шувуу мэт туулагч Бугаржи минь!”

[Лу. АТ] **Суун байн явахуйд**
[Ху. АТ] *Суун байн явахуйд*
[АТНЦ] Суун байн явахуйд

[Лу. АТ] **Солонго бяруу мэт яв.**
[Ху. АТ] *Сулхан бяруу мэт яв*

⁹³ Начин: Махчин шувуу

[АТНЦ]	<u>Сул бяруу мэт яв</u>
[Лу. АТ]	Шоровхийлэх идэвхийлэх үйлст
[Ху. АТ]	<i>Суравхийлах идэвхийлэх үйлд</i>
[АТНЦ]	<u>Саравчилахуй үйлсэд</u>
[Лу. АТ]	Шонхор шувуу мэт довтлон яв.
[Ху. АТ]	<i>Шонхор шувуун мэт довтлон яв</i>
[АТНЦ]	<u>Шонхор шувуу мэт довтлон яв</u>
[Лу. АТ]	Ханьсан эсгэлдэн явахуйд
[Ху. АТ]	<i>Ханицан инээлдэн явахуйд</i>
[АТНЦ]	<u>Ханьсан эсдэн явахуйд</u>
[Лу. АТ. ГЗТ]	Ханилахуй цагт
[Лу. АТ]	Хашин бяруу мэт ханилан яв.
[Ху. АТ]	<i>Хашин бяруу мэт яв</i>
[АТНЦ]	<u>Хашин бяруу мэт яв</u>
[Лу. АТ. ГЗТ]	Хашин хар бяруу мэт аашт
[ХС]	Ханилан явахуй цагт, хашин хар мэт аашит
[Лу. АТ]	Харьтан дайсан лугаа харвалалдахуйд
[Ху. АТ]	<i>Харьтан дайсан харвалдахуйд</i>
[АТНЦ]	<u>Харьтан дайсан лугаа харвалдахуйд</u>
[Лу. АТ. ГЗТ]	Харьтан дайсанд
[Лу. АТ]	Харцгай шувуу мэт довтлон яв, та.
[Ху. АТ]	<i>Харцгай шувуу мэт туулин довтлон яв</i>
[АТНЦ]	<u>Харцагай шувуу мэт довтлон яв</u>
[Лу. АТ. ГЗТ]	Харцгай шувуу мэт туулин довтлон орогч Хүлүг Боорчи минь!
[ХС]	Хартан дайсанд орвоос, харцгай шувуу мэт довтлогч
[Лу. АТ]	Өлссөн барс
[Ху. АТ]	<i>Өлссөн барс</i>
[АТНЦ]	<u>Өлссөн барс</u>
[Лу. АТ]	Өөөрхсэн бүргэд⁹⁴ мэт яв.
[Ху. АТ]	<i>Өөрхсөн бүргэд мэт туулин довтлон яв</i>
[АТНЦ]	<u>Өөөрхсэн бүргэд мэт яв</u>
[Лу. АТ]	Гэгээн өдөр
[АТНЦ]	<u>Гэгээн өдөр</u>

⁹⁴ Өөөрхсэн: Ан хийхээр сойсон бүргэд

[Лу. АТ] **Гэндүү чоно⁹⁵ мэт**

[Лу. АТ] **Гэнэт яв.**

[Ху. АТ] *Гэгээн өдөр гэндүү чоно мэт гэтэн яв*

[АТНЦ] Гэндүү чоно мэт гэтэн яв

Эдгээр бадагт нүүдэлчин монгол хүний хувьд гэр зуурын явдал мөрийг хамгийн энхрий эрх амьтан болох “нялх унага”, “нялх ботготой” зүйрлэсэн бол хатуу үйл хэргийн төлөө зүтгэгсдийг “өлссөн барс”, “өөрхсэн бүргэд”, “гэндүү чонотой” зүйрлэсэн нь мөн л ан агнуурын соёлтой нь холбоотой гэмээр байна.

“Монгол угсаатны жирийн иргэд ч гэсэн харцгай, бүргэд, шонхрын зулгыг үүрнээс нь барьж, гэртээ тэжээн дасгаад, ан авд сургах өвөрмөц арга барилтай байсан агаад түүгээрээ зур, гур, зээр, буга, согоо, үнэг, чоно, туулай, ятуу, гургуул, ногтруу, хахилаг мэтийн жигүүртнийг агнадаг байжээ. Харцгай, бүргэдийг авд сургахдаа урьдаар хулгана, зурмыг бариулж, бялзуухай мэтийн жигүүртнийг шүүрүүлэх, ой шугуйн модны хооронд мах зөөлгөх зэрэг аргаар сургадаг.

Бүргэд, шонхор нь туйлын үнэнч амьтан...Анчид бүргэдээ биедээ дасгаж, амьд холбоо үүсгэж чадаагүй бол бүргэд нь анд нисээд эргэж ирдэггүй, холбоо тушаагаа ганц тоншоод л сул болох бөгөөд ер нь эзэндээ дассан тулдаа л уяа тушаагаа байлгаж байгаа болохоос түүндээ эзлэгдээд байгаа юм байхгүй гэнэ. Бүргэдээр анчлах ёс бол өнөө цагт үлдэж хоцорсон нүүдэлчин ардын ховор нандин соёл билээ⁹⁶” [С. Дулам, 2013, 143-148] хэмээн монголчуудын жигүүртнээр анчлах соёлын тухай бичжээ.

Энд “Бүргэд, шонхор нь туйлын үнэнч амьтан” гэж “өөрхсэн бүргэд”-ийн хамгийн чухал шинжийг хэлснээр аливаа дайн тулаанд туулин довтлохдоо эрэмгий зоригтой, эргэлт буцалтгүй үнэнчээр “Өөрхсэн бүргэд мэт яв” хэмээсний утга учрыг тайлж байна.

[Лу. АТ] **Харанхуй шөнө**

[Лу. АТ] **Хар хэрээ мэт**

[Лу. АТ] **Хатуужин яв.**

[Ху. АТ] *Харанхуй шөнө хар хэрээ мэт хатуужин яв*

[АТНЦ] Харанхуй шөнө хар хэрээ мэт

[АТНЦ] Хатуужин яв

[Лу. АТ] **Жөтгөрч хатан⁹⁷ хүн мэт**

[Лу. АТ] **Хатуужин яв, та нар**

[Ху. АТ] *Хатан хүний жидүгээрч мэт атаархан яв та*

⁹⁵ Гэндүү чоно: Эр чоно

⁹⁶ С.Дулам, *Монгол соёл иргэнийн утга тайлал*, Монгол соёлын чуулган XII боть, Улаанбаатар, 2013.

⁹⁷ **Жөтөөрхөгч хатан:** “ji-” язгуурт үгс нь голдуу хоёрын дотоод харшилдааныг дүрсэлдэг байна. “Жөтөө нь хэтэрбэл чөтгөр болно” [Цэвэл. 1966, 251] гэдэг нь эмсийн хоорондын хонзонгоос хүний санаа саванд багтамгүй зүйл гарна гэсэн үг. Лу.”Алтан товч”-д “jitügerçi qatun kümün metü qataγujin yabu ta” (хоёр эхнэртийн хатан мэт хатуужин яв та) гэхчлэн өгүүлж байдаг нь нэг хүний хоёр эхнэр байхад их хатуужил тэвчээр хэрэгтэйн адил тэвчин явагтун гэсэн үг. [С.Дулам, *Монгол бэлгэдэл зүй I*, Тооны бэлгэдэл зүй, Улаанбаатар, 2007, 36]

Дээрхи хувилбаруудыг харьцуулахад хүн амьтны шчнж төрх, явдал үйлийг зэрэгцүүлэн тавьж оновчтой харшуулжээ. Энэ сургаалын утга агуулга, дүрслэлийг задлан шинжлэхдээ шүлэг зүсэлтийн аргаар хүмүүний оршихуйн хослол “Арга”, “Билиг” гэсэн эсрэгцэл, нэгдлийн харилцан шүтэлцээнд уялдууланхоёр зурваст хуваалаа.

<u>Билиг</u>			<u>Арга</u>		
айл зуур хатуун	алаг бяруу	-наас номхон (мэт)	алалдахад	ал начин	-наас хөдлөгтүн
энгийн үедээ хатуун	итэм бяруу	-наас номхон (мэт)	идэвхийлэхэд	идлэг шувуу	-наас хөдлөгтүн, (мэт)
дуулин)					
халуунд хатууд	хархан бяруу	-наас номхон	хатгалдахад	хар начин	-наас хөдлөгтүн
наадан дуулин	нялх унага	мэт яв,	наад цаад	начин	шувуу
цэнгэхэд	(нялх ботго, идэр зөгий)	(тамтран яв)	лугаа цавчилахуйд		довтлон
суун байн довтлон яв явахад	солонго (сул, мэт яв сулхан) бяруу		шоровхийлох шонхор	үйлст шувуу	мэт
ханьсан довтлон эетэлдэн	хашин бяруу мэт яв (хашин хар	харвалалдахуйд	харцгай	шувуу	мэт яв
явахуйд	бяруу, хашин хар)				

“Монгол хэлний товч тайлбар толь”-д арга билгийг “нарыг арга, сарыг билиг, халууныг арга, хүйтнийг билиг, эрийг арга, эмийг билиг гэх мэтээр эсрэгцэлдэн шүтэн барилдсан хос юм, ухагдахуун”⁹⁸ хэмээн ертөнцийн бүрдэл болохыг тайлбарлажээ. Энэ

⁹⁸ Я.Цэвэл, *Монгол хэлний тайлбар толь*, Нэмж дэлгэрүүлсэн хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2013, 55.

шүлэгт XIII зууны монголчуудын амьдралын хэв маяг, хүний намба төрх, зан араншин, баримтлах зарчмыг сургахдаа эсрэгцүүлсэн атлаа салшгүй нэгдмэл нэгэн зүйл болохыг тод томруун дүрсэлжээ.

Эхний зурваст *айл зуур, энгийн үедээ, наадан цэнгэхэд, суун байн явахад, ханьсан зетэлдэн явахуйд* гэсэн ойролцоо утгат үгсээр дайн тулаангүй амар тайван цагийн өнгө төрх, хүн ардын сэтгэл тэнэгэр, зоо тэнүүн баяр жаргалтай энх цагийг хэлжээ. Ийм үед *алаг бяруу, итэм бяруу, хархан бяруу, нялх унага, нялх ботго, идэр зогий, солонго бяруу, сул бяруу, сулхан бяруу, хашин бяруу, хашин хар бяруу, хашин хар мэт яс* хэмээн хүний номхон дөлгөөн, хар буруу санаагүй, бусдад гай түйтгэр учруулахгүй, эгэл даруу байхыг мах нь махшаагүй, шөл нь шөлшөөгүй нялх балчир бяруугаар төлөөлүүлжээ. Ерөөс үхэр сүр хүчтэй боловч дөлгөөн, амгалангийн бэлгэдэл, биднийг үхэр монгол гэж хэлдэг нь тэнэг гэсэн бус харин монгол хүн тэнгэр шиг агуу мөртөө ууч уужим, даруу төлөв, *эрдэмтэй хүн даруу, их мөрөн дөлгөөн* байхын учрыг энгийн хирнээ хэний ч ой тойнд тод буухаар дүрсэлжээ. “Билиг” хэмээх нь: *Оюун ухаан төрөлхийн гарамгай, авьяас; оюун билиг; ухаан билиг төгс* [Я.Цэвэл, 1966, 83]⁹⁹ гэсэн нь энэ зурваст утга дүйж байна.

Удаах зурваст *алалдах өдрүүдэд, идэвхийлэх дуулих үйлст, хатгалдах өдрүүдэд, наад цаад лугаа цавчилдахуйд, шоровхийлох идэвхийлэх үйлст, харьтан дайсан лугаа харвалдахуйд* буюу орондоо үл орон олзлолдон буй дайн дажинтай самуун цагт *ал начин, идлэг шувуу, хар начин, начин шувуу, шонхор шувуу, харцгай шувуу мэт* сүрлэг, хүчирхэг, дайчин, эрэмгий байхыг захин сургахдаа монголчуудын ан авд сойн сургадаг, сүр хүч, эр чадлын бэлгэдэл начин, шонхор, харцгайгаар төлөөлүүлээд араатнаас *өлссөн барс, жигүүртнээс өөрхсөн бүргэд* мэт хэмээн газар, тэнгэрийн хүчтэнүүдэд хураан зангиджээ.

Чингис хаан Таян хантай байлдахад “*алалдахуй өдөр араны (хүний) мах иддэг, хүрэлцэхүй өдөр хүмүүний мах хүнсэлсэн дөрвөн нохос, Тэмүжин анд минь өлссөн шувуу мэт, гүрүлгү мангас (аварга могой) мэт Хасар*” хэмээн Жамуха уран үгээр Тэмүжин андынхаа сүр хүч, цэрэг эрсийн эр зоригийг магтан, Таян ханы зүрх зоригийг үхүүлж буйтай тохирч байна.

Их эзний айлдсан сургаал ёсоор хүмүүжин төлөвшиж, нийт ард түмний амьдралын хэв маяг, зан суртал болсон тухай хожмын сурвалж, тэмдэглэлүүдээс үзэж болно. Тухайлбал, “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх”-д “*Тэд дайн тулаанд орохдоо догшин араатан мэт, тайван цагт сүү, ноос болон бусад олон ашиг шимээ өгдөг хонь мэт номхон. Гамшиг зовлонгийн үед хоорондоо хэрүүл маргаан үүсгэж эе эвээ үл алдана*” [Ала-ад-Дин Ата-Мелик Жувеини, 2006, 24]¹⁰⁰, “Судрын суулган”-д буй “*Олон түмний дотор нялх тугал мэт номхон бай, дайн тулалдаанд орохдоо өлөн харцага жигүүртэн рүү дайрч байгаа юм шиг бай*” [Рашид-ад-дин, 2002, 406]¹⁰¹ хэмээн монгол хүний эгэл даруухан хирнээ эрхэмсэг, эрэлхэг шинжийг өгүүлжээ.

⁹⁹ Я.Цэвэл, *Монгол хэлний тайлбар толь*, Улаанбаатар, 1966 он, 83

¹⁰⁰ Ала-ад-Дин Ата-Мелик Жувеини, *Дэлхийг байлдан дагуулагчийн түүх*, Тэргүүн боть, Улаанбаатар, 2006, 24.

¹⁰¹ Рашид-ад-дин, *Судрын чуулган*, Нэгдүгээр боть, Орос хэлнээс хөрвүүлсэн Ц.Сүрэнхорлоо, Улаанбаатар, 2002 он, 406.

Сургаалд “гэгээн өдөр гэндүү чоно мэт гэтэн яв, харанхуй шөнө хар хэрээ мэт хатуужин яв” хэмээн гэгээн, харанхуйгаар ертөнцийг төлөөлүүлэн хураангуйлаад, болгоомж сэрэмжтэй, хатуужих тэр дундаа “жсөтгөрч хатан хүн шиг хатуужин яв” хэмээн төгсгөсөн нь санамсаргүй хэрэг бус харин Хасарын хоёр сэтгэл гарган¹⁰² эзнээс урван дутааж эм хүн лүгээ аашилсныг шүүмжлээд, хоёр эхнэртийн хатан мэт торгон ухаан, мяндсан мэдрэмж, тэсвэр тэвчээр, бат журамт сэтгэлээр хатуужих хэрэгтэйг сануулан сургамжилсан цогц санаа бүхий сургаал юм.

Монгол хүний сэтгэлгээнд нүүдлийн ахуй амьдрал, мал аж ахуй, ан агнуур, араатан, жигүүртэний авир төрх, үйл хөдлөл, өвөрмөц онцлогийг хамгийн сайн мэддэг тул хүний зан чанар, үйл хэрэгтэй эн зэрэгцүүлэн дүрсэлсэн шүлэг олон байна. Жишээлбэл, Тэмүүжин, Хасар хоёр Бэгтэрийг харваж алахад Өүлэн эх “хуучин үгс хадлан, өмгөс үг орхидон” хилэгнэн зэмлэхдээ:

[MHT §78]

qarbisu-ban qajaqu qasar noqoi metü
qada-tur dobtulqu qablan metü
a'ur-iyen darun yadaqu arslan metü
amidu jalgisu kēgü manggus metü
se'üder-tür-iyen dobtulqu singqor metü
sem-iyer jalgiqu curaqu metü
botoqan-iyen borbi qajaqu bu'ura metü
boroqan-tur siqaqu cinō metü
ku'üd-iyen gelin yadaju ku'üd-iyen idegü anggir metü
kebdesi-yen kunde'esüümērgü cu'eburi metü
bariju ülü sa'araqu bars metü

baramut dobtulqu baru[q] metü [Igor de Rachewiltz, 1972, 30]¹⁰³ хэмээн ахан дүүсийн эе эв, элбэрэл журмыг умартан хүн чанаргүй балмад аашилсныг хасар нохой, хаблан, арслан, мангас, шонхор, чоно зэрэг зэрлэг догшин араатан, жигүүртэнээр зүйрлэн дүрсэлжээ.

Чингис хааны билиг сургаалд хүмүүний тэсвэр хатуужил, уян хатан чанарыг араатан амьтны авир төрхтэй зүйрлэн дүрсэлж, эсрэгцүүлэн харшуулж, эн зэрэгцүүлэн дүрсэлсэн утга төгс, уран яруу шүлгүүд олон байна. Үүнийг монгол хүний дүрслэх

¹⁰² “Чингис хааны алтан товч нэртний цэдиэ”-т Хасар эзнээс урван дутааж, хоёр сэтгэл гарган өөрийн биеийг ихэд өргөмжилөхөд сурган өгүүлсэн нэгэн домог буй. Энд “Хасарын хав Бэлгэтэй бөхөөр таван өнгө, дөрвөн харь их улсыг эрхэндээ оруулбай за хэмээн хэлэлцэн явахуйг эзэн мэдээд, тэдний энэ омгийг нь даруулъя хэмээн сэтгэж, доорд нэгэн муу өвгөн хүн болон хувилж, нэгэн уртагчин шар нум барьж, худалдъя хэмээн сураглан явбай. Тэндээс Хасар Бэлгэтэй хоёр ийм эс үзэгдсэн хүн хаанаас ирсэн буй гэж тэр өвгөнөөс асуув. Тэр өвгөн өгүүллүүн: Би яданги хүн нум худалдаж яван аму хэмээв. Төдий тэр хоёр энэ нумыг чинь авъя хэмээн доромжлов. Тэр өвгөн өгүүллүүн: Муу ч болов хөвчилж мэдээсэй гэв. Төдий Бэлгэтэй аваад хөвчилж эс чадав. Тэр өвгөн аваад, хөвчилж Хасарт өгөв. Хасар аваад тэлж эс даав. Тэндээс тэр өвгөн хөх халзан луус унасан буурал үст өвгөн хүн болоод, уртагчин шар нуманд алтан тоололжсоо онилж хадыг хадтал, харваад, Богд эзний Хавт Хасар, Бөх Бэлгэтэй гэгч хоёр дүү нь та мөн буюу. “Их хэлэхээр их үмх” гэлээ гэж донгодоод явбай. Тэр хоёр дүү нь эмээж, айж, эзний бидний сүлд нь энэ буюу хэмээн өгүүлэлдвэй. Түүний хойно, тэдний омог нь байлаа гэх.”

¹⁰³ Igor de Rachewiltz, *Index to The Secret History of the Mongols*, by Indiana University, Bloomington 1972, pp.

сэтгэлгээ илүү хөгжсөнтэй холбон тайлбарлаж болох бөгөөд монгол ардын аман зохиолд ийм дүрслэл нэн элбэг билээ.

SUMMARY

Mongolian human mind of the beast and fowl disposition and conduct, because it is closest to the unique human character, and should be a priority parallel verse describes folklore is rich. Genghis Khan's teaching human intelligence, durability and flexibility compared predators disposition, and described, along with the values matched perfect, eloquent, poetic style. Wisdom teachings eloquent herders living expression of graphics, the idea of using the instrument's life and culture surrounding mental development.

НОМЗҮЙ

1. Ала-ад-Дин Ата-Мелик Жувейни, *Дэлхийг байлдан дагуулагчийн түүх*, Тэргүүн боть, Улаанбаатар, 2006
2. Дулам. С, *Домог зүйн дүр*, Улаанбаатар, 2009
3. С. Дулам, Монгол бэлгэдэл зүй I боть, *Тооны бэлгэдэл зүй*, Улаанбаатар, 2007
4. Igor de Rachewiltz, *Index to The Secret History of the Mongols*, by Indiana University, Bloomington, 1972
5. В. Инжаннаши, *“Хөх судар”*, Тэргүүн дэвтэр, Кирилл үсэгт хөрвүүлсэн Ш. Чоймаа, М. Баярсайхан, Улаанбаатар, 2005
6. Lubsangdanjin, *Erten-ь qad-un ьndьsblegsen tьrь yosun-u jokiyal-i tobčilan quriyaγsan altan tobči kemekü orusibai*. Orusil bičigsen Ša. Bira, Ulus-un tōb nom-un sang-dur qadaγalaydaju bui Lubsangdanjin-u γar bičimel eke-eče gerel jiruy beledkegsen So. Törübatu, Ulus-un keblel-ьn γajar, Ulaγanbayatur, 1990
7. Рашид-ад-дин, *Судрын чуулган*, Нэг, хоёрдугаар боть, Орос хэлнээс хөрвүүлсэн Ц. Сүрэнхорлоо, Улаанбаатар, 2002 он,
8. Sagang Secen, *“Erdeni-yin tobci”*, (Precious Summary’), The Urga text transcribed and edited by, M. Go, I. de. Rachewiltz, J. R. Krueger and B. Ulaan, Faculty of Asian studies, The Anstralian National University, 1990
9. *Хаадын үндсэн хураангуй алтан товч*, Тэргүүн дэвтэр, Галиглаж үгийн хэлхээ үйлдэн, эх бичгийн судалгаа хийсэн Ш. Чоймаа, Улаанбаатар, 2002
10. *Чингис хааны алтан товч нэртний цэдиг*, Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн С. Дашдэжид, Улаанбаатар, 2006
11. Я. Цэвэл, *Монгол хэлний тайлбар толь*, Нэмж дэлгэрүүлсэн хоёрдугаар хэвлэл, Улаанбаатар, 2013
12. Я. Цэвэл, *Монгол хэлний тайлбар толь*, Улаанбаатар, 1966